

Япон улсад оршин суух бүртгэлтэй гадаадын иргэдэд: Хувийн Дугаар (Миний дугаар)-ын талаарх мэдээлэл

Нийгмийн даатгал, татвар, гамшгийн үед авах арга хэмжээний хүрээнд Нийгмийн даатгал, Татварын дугаар (Хувийн Дугаар эсвэл “Миний дугаар” гэж нэрлэгдэх) - ыг 2016 оны 1-р сараас ашиглаж эхэллээ.

1. Хувийн Дугаар гэж юу вэ?

Хувийн Дугаар (“Миний дугаар” гэгдэх) гэдэг нь Япон улсад оршин суугаа иргэдэд Нийгмийн даатгал, Татварын дугаарын системийн дагуу олгосон, нийгмийн даатгал, татвар, гамшгийн үед авах арга хэмжээний хүрээнд ашиглагдах 12 орон бүхий дугаар юм. Энэ систем нь засаг захиргааны ил тод байдлыг сайжруулж, ард иргэдийн ая тухыг дээд зэргээр хангах, шударга, ёс зүйтэй нийгмийг бүтээх зорилго бүхий нийгмийн дэд бүтцийн үүрэг гүйцэтгэнэ.

Япон улсад оршин суух бүртгэлтэй гадаадын иргэд (дунд-хугацааны оршин суугч, байнгын оршин суугч гэх мэт) мөн Хувийн Дугаартай байх болно.

2. Хувийн Дугаарын бүртгэл

- ◆ Хэрэв та Япон улсад оршин суугчаар бүртгүүлсэн бол харьяа нутаг дэвсгэрийн засаг захиргааны байгууллагаас танд олгох бүртгэлийн карт дээр таны Хувийн Дугаарыг хэвлэсэн байх болно. (Бүртгэлийн картын хугацаа дуусна гэж байхгүй бөгөөд түүнийг хаяж үрэгдүүлэлгүй нямбайлан хадгалах хэрэгтэй.)
- ◆ Дунд - урт хугацааны оршин суух статусаар Японд байгаа гадаадын иргэд оршин суух бүртгэл хийлгэх үедээ Хувийн Дугаараа авна.

3. Хувийн Дугаарыг ямар тохиолдолд ашиглах вэ?

- ◆ Та 2016 оны татварын буцаалтын баримтаа бүрдүүлэх гэх мэт болон бусад татвартай холбоотой хэргээр татварын газарт хандахад Хувийн Дугаараа ашиглана.
- ◆ Таны татвар, нийгмийн даатгаллын үйлчилгээний зорилгоор ажил олгогч таны Хувийн Дугаарыг ашиглаж болно.
- ◆ Үнэт цаасны фирм болон Даатгалын компани дээр татвар тооцох зорилгоор таны Хувийн Дугаарыг шаардана.
- ◆ Халамжийн тэтгэмж авах болон Үндэсний Эрүүл Мэндийн Даатгал, Асран Хамгаалах Даатгалын Хөтөлбөрийн үйл ажиллагаанд хамрагдахад харьяа орон нутгийн захиргаанд Хувийн Дугаараараа хандана.
- ◆ Гадаад руу мөнгө шилжүүлэх, гадаадаас хүлээн авах тохиолдолд банк болон шуудангийн үйлчилгээнд Хувийн Дугаараа ашиглана.

Жич: Дээрх үйлчилгээг авах үед хууль бус бичиг баримттай холбоотой үйлдлээс сэргийлэх үүднээс таны Хувийн Дугаарыг ашиглаж буй байгууллага (1) дугаарын хүчинтэй эсэх (2) карт эзэмшигч өөрөө мөн эсэхийг шалгаж баталгаажуулна.

Бүртгэлийн карт нь зөвхөн дугаарын баталгаа болох түл та өөрийн биеийн байцаалт (оршин суух үнэмлэх, байнгын оршин суугчийн үнэмлэх) – аа үзүүлэх шаардлагатай болно.

4. Хувийн Дугаарын Карт (Миний Дугаарын Карт) гэж юу вэ?

- ◆ Энэхүү карт нь таны Хувийн Дугаартай холбоотой бүхий л үйл ажиллагаанд Хувийн Дугаар болон таныг мөн эсэхийг аль алиныг баталгаажуулах баримт бичиг юм. Мөн энэхүү карт нь таны албан ёсны биеийн байцаалтын үүргээр ашиглагдаж болно.
- ◆ Та Хувийн Дугаарын Карт захиалах боломжтой. Захиалах хэд хэдэн хувилбар байгаа бөгөөд жишээлбэл та өргөдлийн маягт(Бүртгэлийн карттай хамт хүлээн авсан) - ыг цээж зургийн хамтаар шуудангаар илгээх боломжтой, эсвэл компьютер болон ухаалаг утас ашиглан онлайнаар хүсэлт гаргаж болно. Картыг анх удаа авахад үнэ төлбөргүй байна.
- ◆ Хувийн Дугаарын Картын хүсэлт илгээсний дараа таны картыг хэвлэхэд бэлэн

болсон тухай мэдэгдэл бүхий ил захидал хүлээн авна. Та орон нутгийн захиргаанаас картаа авахаар очихдоо (1) мэдэгдэл бүхий ил захидал, (2) таны бүртгэлийн карт, (3) биеийн байцаалт (оршин суух үнэмлэх зэрэг) – аа биедээ авч ирээрэй. Карт хэвлүүлэхдээ иргэний бүртгэлийн дугаараа картандаа суулгуулна.

- ◆ Хэрэв та 20 буюу түүнээс дээш настай бол Хувийн Дугаарын Карт авснаас хойшхи 10 дахь төрсөн өдөр хүртэл, 20 нас хүрээгүй бол 5 дахь төрсөн өдөр хүртэл таны карт хүчинтэй байна. Таны оршин суух хугацаа болон бусад нөхцөлөөс шалтгаалан картын хүчинтэй хугацаа өөрчлөгдөж болохыг анхаарна уу.
- ◆ Таны карт нь татварын буцаалтыг онлайнгаар авах болон бусад зүйлд ашиглагдах цахим үнэмлэхийг агуулсан чиптэй байна.
- ◆ Та зарим орон нутагт нийгмийн үйлчилгээ (нийтийн номын сан, тамга, тэмдэгийн бүртгэл зэрэг) авах эсвэл сүлжээ дэлгүүрээс оршин суух үнэмлэхний хуулбарыг авахад Картаа ашиглах боломжтой.
- ◆ Таны Хувийн Дугаарын картын чип-д таны нэр, хаяг, Хувийн Дугаар, Картын нүүрэн дээр бичигдсэн бусад мэдээлэл багтах болно. Таны орлогын мэдээлэл гэх мэт хувийн, нууцлалтай мэдээллийг энд бүртгэхгүй.
- ◆ Хувийн Дугаарын Картаа авсны дараа ч гэсэн та оршин суух үнэмлэх, байнгын оршин суугчийн үнэмлэх зэргийг хаялгүй хадгалж байх хэрэгтэй шүү.

5. Хувийн Дугаарыг хэрэглэхэд анхаарах зүйлс

- ◆ Бүртгэлийн карт болон Хувийн Дугаарын Карт дээрх хаяг ба бусад мэдээллийг шинэчлэх шаардлагатай бол орон нутгийн захиргаанд хандана уу.
- ◆ Ямар ч этгээд хуулиар зөвшөөрөөгүй тохиолдолд таны Хувийн Дугаарыг хураах болон ашиглахыг хориглоно. Хэн нэгэн таны Хувийн Дугаарыг асуусан тохиолдолд хэн, ямар зорилгоор ашиглах гэж байгааг сайтар шалгаж нягтална уу.
- ◆ Бусдын Хувийн Дугаарыг хууль бусаар эзэмшсэн тохиолдолд хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.
- ◆ Хувийн Дугаараа бусдад, ялангуяа сэжиг бүхий утасны дуудлага хийсэн хүнд санамсаргүй байдлаар хэлэхгүй байхад анхаарна уу.

6. Хувийн Дугаарын талаар мэдээлэл авах

- ◆ Англи, Хятад, Солонгос, Испани, Португал хэл дээр дуудлага хүлээн авах үнэгүй утас:
0120-0178-26 **Нийгмийн даатгал, Татварын дугаарын Системийн талаарх мэдээлэл**
0120-0178-27 **Бүртгэлийн карт, Хувийн Дугаарын Картын талаарх мэдээлэл**
 - 9:30-20:00 ажлын өдрүүдээр, 9:30-17:30 амралтын өдрүүд, бүх нийтийн амралт, баярын өдрүүдээр (Шинэ жилийн баярын өдрүүдэд ажиллахгүй)
 - Хувийн Дугаарын Картаа гэсэн, хулгайд алдсан тохиолдолд хүчингүй болгох яаралтай арга хэмжээ авах бол 24/7 цагаар ажиллах 0120-0178-27 дугаарт хандана уу.
- ◆ Хувийн Дугаарын талаар гадаад хэл дээрх мэдээллийг дараах цахим хуудаснаас авна уу.
 - Cabinet Secretariat: <http://www.cas.go.jp/jp/seisaku/bangoseido/>
 - J-LIS: <https://www.kojinbango-card.go.jp/>



Хүн бүрт өөрийн гэсэн цор ганц Хувийн Дугаар олгогдсон байдаг. Түүнийг болгоомжтой ашиглаарай.